15.4 Supplier undertakes to specify in writing to Sandvik at the earliest opportunity and, prior to accepting a Purchase Order, any Goods, parts, components or devices included in the Goods which are subject to export restrictions in the country of manufacture or in the countries where any of the Goods, parts or components incorporated in the Goods originate from. Supplier shall also specify the scope of such export restrictions. Supplier shall always provide Sandvik without undue delay and in appropriate language: a valid certificate of origin for supplied Goods (including included US components); a valid HS Code (the code of the Harmonized System, or the Harmonized Commodity Description and Coding System, which is an internationally standardized system of names and numbers to classify traded products, developed and maintained by the World Customs Organization); a valid Long Term Declaration (the Supplier's one-off declaration which is valid for consignments over a longer period of time and which can be made out for any consignments delivered during a period up to a maximum of two years) or a certificate of preferential origin; a declaration of conformity; a valid item test certificate; the current customs certification program participation status (C-TPAT, AEO, etc.); an up to date MSDS sheet (the material safety data sheet prepared in accordance with the laws and regulations applicable to the delivery and the Goods); an ECCN (the Export Control Classification Number, as listed in the Commerce Control List (Supplement No. 1 to Part 774 of the U.S. Export Administration Regulations)) relating to the Goods; and advanced manifest details. Sandvik shall make available its Supplier Trade Data Guideline upon request.

15.5 The Goods shall be CE- marked (the symbol affixed to products before they can be sold on the European market, indicating that a product fulfills the requirements of relevant European product directives; meets all the requirements of the relevant recognized European harmonized performance and safety standards; and is fit for its purpose and will not endanger lives or property) according to valid EU rules (or in accordance with similar quality and/or authority certification/requirements for any country outside of EU). The Goods shall be in compliance with any environmental and safety regulations prescribed in the law or by the authorities in the country where the Goods will be manufactured/operating/used.

15.6 Supplier undertakes to comply with any and all Data Protection Legislation, as well as with the Agreement, including any appended data protection agreement, when processing personal data under the Agreement. Supplier may only process personal data under the Agreement in accordance with Sandvik's instructions as applicable from time to time and shall not be entitled to process personal data under the

гүйцэтгэгч эсхүл зөвлөх бие даан боловсруулсан бөгөөд үүнийг бичгээр эсхүл бусад үндэслэлтэй нотлох боломжтой мэдээлэл; (e) хууль тогтоомж, үнэт цаасны бирж зэрэг аливаа төрийн эсхүл захиргааны байгууллагын шаардлага, эсхүл шүүхийн шийдвэрийн дагуу заавал ил болгох шаардлагатай мэдээлэллийг нөгөө Талд урьдчилсан мэдэгдсэний үндсэн дээр; (f) энэхүү Гэрээний зорилгын хүрээнд хууль зүйн эсхүл санхүүгийн зөвлөхүүд заавал мэдэх шаардлагатай Нууц мэдээлэл; эсхүл (g) Хориг арга хэмжээтэй холбоотой зөвлөгөө авах, лиценз эсхүл зөвшөөрөл авах зорилгоор Хориг арга хэмжээ авах байгууллагад нөгөө Талд урьдчилан мэдэгдэн, бичгээр зөвшөөрөл авсны үндсэн дээр ил болгосон мэдээлэл. Дээрх (a), (b), (c), (e), (f)-д хамаарах тохиолдолд хүлээн авагч Тал тухайн мэдээллийг нөгөө Талаас авсан гэдгийг мөн нууцлах үүрэгтэй..

14.3 Хүлээн авагч Тал нууцлалын аль нэг заалтыг зөрчсөн тохиолдолд уг зөрчлөөс шууд эсхүл шууд бусаар үүссэн аливаа нэхэмжлэл, хариуцлага, алдагдал, хохирол, зардал (үүнд өмгөөлөгчийн хөлс болон зардлыг бүрэн нөхөн төлөхөөр багтаана)-ыг ил болгосон Талд бүрэн нөхөн төлнө.

14.4 Дээрхийг үл харгалзан, хүлээн авагч Тал нь энэхүү Гэрээнд заасан зорилгоор Нууц мэдээллийг мэдэх шаардлагатай өөрийн Нэгдмэл сонирхолтой этгээдүүд болон тэдгээрийн захирлууд, удирдах ажилтнууд, зөвлөхүүдэд ил болгож болно. Ингэхдээ хүлээн авагч Тал нь тэдгээр этгээдүүдтэй энэхүү нөхцөлтэй адил нууцлалын үүрэг бүхий гэрээ байгуулна. Үүнээс үл хамааран, өөрийн Нэгдмэл сонирхолтой этгээдүүд болон тэдгээрийн захирлууд, удирдах ажилтнууд, зөвлөхүүд энэхүү Гэрээ болон эдгээр Нөхцөлийн дагуу нууцлалын үүргээ сахин биелүүлэхэд ил болгож буй Тал нь бүхэлд нь хариуцлага хүлээнэ.

15 НИЙЦЭЛ

15.1 Нийлүүлэгч нь энэхүү Гэрээтэй холбоотойгоор өөрийн үүргээ гүйцэтгэхдээ Сэндвикийн Нийлүүлэгчийн Ёс зүйн дүрэм (Сэндвикийн вэбсайтад нийтлэгдсэн), Албадан хөдөлмөр, боолчлолын эсрэг хууль болон Авилгалын эсрэг хуулийг дагаж мөрдөх үүрэг хүлээнэ. Нийлүүлэгч нь Барааг нийлүүлэхэд оролцож буй өөрийн бүх туслан гүйцэтгэгч болон дэд нийлүүлэгчийн сүлжээ нь мөн Сэндвикийн Нийлүүлэгчийн Ёс зүйн дүрэм, Албадан хөдөлмөр, боолчлолын эсрэг хууль болон Авилгалын эсрэгхуулийг дагаж мөрдөх асуудлыг хариуцна.

15.2 Нийлүүлэгч нь Барааны химийн бодис болон аюултай бодисийн хэрэглээнд хамаарах хязгаарлалт, бүртгэл, үнэлгээ, зөвшөөрөл зэрэгтэй холбоотой бүхий л холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын нийцлийг хангах үүрэгтэй.

15.3 Нийлүүлэгч нь нь Бараг ашиглахтай холбоотой байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй байдалд хамаарах хууль тогтоомж, лиценз, зөвшөөрлийн шаардлагыг бүрэн хангах боломжийг Сэндвикт олгох үүднээс Барааны талаарх холбогдох бүх Баримт бичиг болон мэдээллийг Сэндвикт өгөх үүрэгтэй.

15.4 Нийлүүлэгч нь боломжит хамгийн эрт үед, Захиалгын хуудсыг хүлээн зөвшөөрөхөөс өмнө гарал үүслийн экспортын хязгаарлалтад хамаарах аливаа Бараа, эд анги, бүрэлдэхүүн хэсэг эсхүл төхөөрөмж байгаа эсэхийг Сэндвикд бичгээр тодорхой мэдэгдэнэ. Мөн тухайн экспортын хязгаарлалтын хамрах хүрээг тодорхой заана. Нийлүүлэгч нь дараах баримт бичиг, мэдээллийг үндэслэлгүйгээр хугацаа хэтрүүлэлгүйгээр зохих хэл дээр Сэндвикд тухай бүр гаргаж өгөх үүрэгтэй: Нийлүүлсэн Барааны хүчин төгөлдөр гарал үүслийн гэрчилгээ (АНУ-ын Бараанд хамаарах бүрэлдэхүүн хэсгүүдийг оролцуулан); хүчин төгөлдөр HS код; хүчин төгөлдөр Урт хугацааны мэдүүлэг эсвэл хөнгөлөлттэй гарал үүслийн гэрчилгээ; тохирлын гэрчилгээ; хүчин төгөлдөр барааны туршилтын гэрчилгээ; гаалийн гэрчилгээжүүлэлтийн хөтөлбөрт хамрагдсан эсэх (CTPAT, AEO гэх мэт); хамгийн сүүлийн үеийн MSDS (материалын аюулгүй ажиллагааны мэдээллийн хуудас); Бараанд холбогдох ECCN (Экспортын хяналтын ангиллын дугаар); болон ачааны урьдчилсан дэлгэрэнгүй мэдээлэл. Нийлүүлэгч нь Сэндвикийн хүсэлтээр өөрийн Худалдааны Өгөгдлийн Удирдамжийг гаргаж өгнө.

15.5 Бараа нь Европын Холбооны хүчин төгөлдөр дүрмийн (ЕХ-ооc гадуурх улсад ижил төстэй чанарын болон/эсхүл эрх бүхий байгууллагын гэрчилгээ, шаардлагад нийцсэн байх) дагуу CE-тэмдэглэгээтэй (Европын зах зээлд бүтээгдэхүүнийг борлуулахаас өмнө наадаг тэмдэг бөгөөд энэ нь тухайн бүтээгдэхүүн нь Европын холбогдох бүтээгдэхүүний удирдамжийн шаардлага; уялдуулсан стандарт болон аюулгүй байдлын шаардлагуудыг бүрэн хангасан, зориулалтдаа бүрэн нийцсэн, хүний амь нас, эд хөрөнгөд аюул учруулахгүй гэдгийг илэрхийлдэг) байна. Бараа нь үйлдвэрлэгдэх, ашиглагдах улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй байгаль орчин, аюулгүй байдалд хамаарах хууль тогтоомж, эрх бүхий байгууллагын шаардлагад нийцсэн байна.

15.6 Нийлүүлэгч нь энэхүү Гэрээний хүрээнд хувийн мэдээлэл боловсруулах тохиолдолд бүх холбогдох Мэдээлэл хамгаалах тухай хууль тогтоомж, мөн Гэрээ болон түүнд хавсаргасан мэдээлэл боловсруулах аливаа гэрээг дагаж мөрдөнө. Нийлүүлэгч нь хувийн мэдээллийг зөвхөн Сэндвикийн тухайн үед өгсөн зааврын дагуу, Гэрээний үүргийг биелүүлэхэд зайлшгүй шаардлагатай хэмжээнд л боловсруулна. Иймээс ажиллагааны хүрээнд Нийлүүлэгч нь боловсруулж буй хувийн мэдээллийг хамгаалахад шаардлагатай

Copyright © 2026 Sandvik Group – All rights reserved

Agreement for any purpose or in any manner other than is necessary to perform obligations pursuant to the Agreement. Where Supplier processes personal data in connection with the provision of the Goods or otherwise in the performance of its obligations under the Agreement, it is acknowledged that Supplier shall take all such appropriate technical and organizational measures in order to protect the personal data processed under the Agreement. If the Parties have not concluded a data processing agreement (either separately or by attaching such an agreement as an integral part of the Agreement), Supplier is not allowed to process any personal data or on behalf of Sandvik.

15.7 If the Supplier becomes aware or suspects that there has been unauthorised access, modification, disclosure or other misuse or interference with any Personal Information (as defined under the Data Protection Legislation) which it collects, stores, and handles (Data Breach), the Supplier must immediately notify Sandvik of that Data Breach. The Supplier must promptly disclose to Sandvik all information relevant to that actual or suspected Data Breach and provide Sandvik with access to the copies of relevant records relating to the investigation. Without limiting the Supplier's other obligations under this Agreement, if the Supplier becomes aware of a Data Breach, the Supplier must, at its own cost, and as a matter of priority (i) take all reasonable steps to contain and remedy the Data Breach; and (ii) take appropriate remedial action to prevent the affected Personal Information from further breach.

15.8 At Sandvik's request, the Supplier must (at the Supplier's cost) provide all reasonable assistance (including the provision of information, access to documents and the Supplier's personnel) as Sandvik may require from time to time, including to investigate any actual, alleged or reasonably suspected breaches by the Supplier or its employees of the Code of Conduct, Anti-Slavery Laws or ABC Laws.

15.9 If Sandvik exercises its right under Clause 17.1 because of a failure to comply with requirements of the Code of Conduct, Anti-Slavery Laws or ABC Laws, Sandvik (i) will not be liable for any losses suffered by the Supplier; and (ii) the Supplier provides a release and indemnity to Sandvik in respect of any losses incurred by the Supplier.

15.10 Supplier represents and warrants that none of the Supplier, nor any employees of the Supplier, or any agent, Affiliate, or other person acting on behalf of the Supplier, is currently (or is otherwise controlled by) Sanctioned Person or otherwise the subject or the target of any Sanctions.

15.11 Supplier represents and warrants from the date of this Agreement and on an ongoing basis that it, and its Related Entities, shall: (a) strictly comply with, and adhere to, all Sanctions; (b) not engage in any activity, practice or conduct involving Sanctioned Person or Prohibited Country; (c) not engage in any activity, practice or conduct that would breach Sanctions, cause Sandvik or its Related Entities to breach Sanctions, or that could expose it, Sandvik or Sandvik's Related Entities to the risk of adverse measures pursuant to any Sanctions (including being designated as Sanctioned Person); (d) inform Sandvik immediately if any person who directly or indirectly owns or controls (as those terms are understood pursuant to Sanctions) Supplier is or becomes a Sanctioned Person; and (e) maintain its own policies and procedures to ensure compliance with Sanctions (and the Sanctions-related provisions in this Agreement).

15.12 Supplier shall cause all subcontractors to give and enter into representations, warranties and undertakings substantially equivalent to those set out in Clause 15.8. Nothing in this Agreement requires either Party to take any action, or refrain from taking any action, where doing so would be prohibited by, or subject to penalty under, any Sanctions, or where doing so would expose the Party or their Related Entities to the risk of adverse measures pursuant to any Sanctions.

15.13 Supplier undertakes to take all reasonable measures to ensure that its employees, subcontractors, agents, and representatives will comply with the Sanctions-related terms of this Agreement. For the purposes of this Clause 15.10, reasonable measures include, but is not limited to, Supplier establishing and/or maintaining policies, procedures and carrying out training relating to compliance with Sanctions.

15.14 Each Party agrees to take advantage of any general licence to lawfully allow for performance of the terms of this Agreement if such performance is affected by Sanctions. For the avoidance of doubt, nothing in this Agreement, or otherwise, requires any Party to apply for any specific licence or authorization in the event that performance of the terms of this Agreement becomes unlawful pursuant to Sanctions.

15.15 If Supplier breaches any representation or warranty set out in Clauses 15.1, 15.10 or 15.11 of this Agreement or, in Sandvik's reasonable opinion, any such breach is likely to occur, Parties agree that Sandvik may terminate or suspend, at its own discretion, its relationship with Supplier immediately, and that Sandvik shall not be liable toward Supplier, or any third party for any subsequent non-performance by Sandvik under this Agreement, and that Supplier shall indemnify and hold Sandvik harmless from any claims or losses relating to such non-performance or otherwise arising from such breach of representation or warranty.

15.16 If Sandvik elects to suspend the Agreement pursuant to Clause 15.12: (a) Supplier will cease performance of any supply of Goods with immediate effect upon being provided with a written notice of such suspension; (b) Supplier shall make available to Sandvik information concerning compliance with the obligations under Clauses 15.1, 15.7 and 15.8 within two (2) weeks of the simple request of such information; (c) Any suspension will last for a period of up to 120 days. If, after this period, Sandvik is unable to confirm that the Supplier is in compliance with Clauses 15.1, 15.7 and 15.8 of this Agreement, Sandvik may elect to terminate the Agreement with immediate effect; (d) For the suspension to cease having effect, Sandvik must serve Supplier with a written notice confirming that the suspension period has come to an end.

техникийн болон зохион байгуулалтын зохих арга хэмжээг авна. Хэрэв Талууд мэдээлэл боловсруулах гэрээг тусад нь эсхүл Гэрээний салшгүй хэсэг болгон байгуулаагүй бол Нийлүүлэгч нь Сэндвикийн нэрийн өмнөөс хувийн мэдээлэл боловсруулах эрхгүй.

15.7 Нийлүүлэгч нь өөрийн цуглуулж, хадгалж, боловсруулж буй Хувийн Мэдээлэлд (Мэдээлэл хамгаалах тухай хууль тогтоомжид зааснаар) зөвшөөрөлгүй нэвтрэлт, өөрчлөлт, задрал, зүй бус ашиглалт, хөндлөнгийн нөлөөлөл гарсан, эсхүл гарсан байж болзошгүй (Мэдээллийн/Өгөгдлийн зөрчил) талаар мэдсэн даруйд Сэндвикд нэн даруй мэдэгдэнэ. Нийлүүлэгч нь уг бодит эсхүл сэжигтэй Өгөгдлийн зөрчилтэй холбоотой бүх мэдээллийг сааталгүйгээр ил болгож, шалгалтад хамаарах баримтын хуулбарыг Сэндвикд гаргаж өгнө. Үүнээс гадна Нийлүүлэгч нь өөрийн зардлаар, нэн тэргүүнд: (i) Өгөгдлийн зөрчлийг хязгаарлах, засах бүх боломжит арга хэмжээг авах; (ii) зөрчигдсөн хувийн мэдээллийг дахин зөрчигдөхөөс сэргийлэхэд шаардлагатай зохих засварлах арга хэмжээг авна.

15.8 Сэндвикийн хүсэлтээр Нийлүүлэгч нь (өөрийн зардлаар) Нийлүүлэгчийн эсхүл түүний ажилтнууд Ёс зүйн дүрэм, Албадан хөдөлмөр, боолчлолын эсрэг хууль болон Авилгалын эсрэг хуулиудыг зөрчсөн эсэхийг шалгах болон бусад асуудлаар тухай бүрт Сандвикт шаардлагатай боломжит бүхий л туслалцааг (мэдээлэл өгөх, баримтад нэвтрэх эрх олгох, ажилтнуудаа оролцуулах зэрэг) үзүүлэх үүрэгтэй.

15.9 Хэрэв Сэндвик нь Ёс зүйн дүрэм, Албадан хөдөлмөр, боолчлолын эсрэг хууль эсхүл Авилгалын эсрэг хуулийг зөрчсөний улмаас Зүйл 17.1-д дагуу эрхээ хэрэгжүүлсэн бол: (i) Сэндвик Нийлүүлэгчид учирсан аливаа алдагдалд хариуцлага хүлээхгүй; (ii) Нийлүүлэгч нь уг хохирол, алдагдалын хувьд Сэндвикийг хариуцлагаас чөлөөлөх бөгөөд хохиролгүй болгох баталгаа гаргаж өгнө.

15.10 Нийлүүлэгч нь өөрөө, түүний аль ч ажилтан, төлөөлөгч, Нэгдмэл сонирхолтой этгээд, эсхүл өөрийн нэрийн өмнөөс ажиллаж буй аливаа этгээд нь одоогоор Хориг арга хэмжээ авагдсан этгээд биш бөгөөд мөн тийм этгээдийн хяналтад ороогүй болохыг мэдэгдэж, баталж байна.

15.11 Нийлүүлэгч болон түүний Хамаарал бүхий этгээдүүд нь энэхүү Гэрээний огнооноос эхлэн цаашид тасралтгүй дараах үүргийг биелүүлэхээ мэдэгдэж, баталгаажуулж байна: (a) бүх Хориг арга хэмжээнүүдийг чандлан дагаж мөрдөх; (b) Хориг арга хэмжээ авагдсан этгээд эсхүл Хориглосон улстай холбоотой аливаа үйл ажиллагаанд оролцохгүй байх; (c) Хориг арга хэмжээг зөрчих, Сэндвик эсхүл түүний Хамаарал бүхий этгээдүүдийг зөрчилд оруулах, эсхүл сөрөг арга хэмжээнд өртүүлэх эрсдэлтэй үйл ажиллагаа явуулахгүй байх; (d) Нийлүүлэгчийг шууд эсхүл шууд бусаар өмчилж, хянаж буй аливаа этгээдэд Хориг арга хэмжээ авагдсан тохиолдолд Сэндвикд нэн даруй мэдэгдэх; (e) Хориг арга хэмжээний шаардлагыг хангах дотоод бодлого, журамтай байх, тэдгээрийг хэрэгжүүлэх.

15.12 Нийлүүлэгч нь бүх туслан гүйцэтгэгчдээрээ Зүйл 15.8-д заасантай үндсэндээ дүйцэхүйц мэдэгдэл, баталгаа болон үүрэг амлалтуудыг гаргуулах бөгөөд тийм нөхцөлийг зөвшөөрүүлэх үүрэгтэй. Энэхүү Гэрээний аль ч заалт нь аль нэг Талаас аливаа Хориг арга хэмжээний дагуу хориглосон эсвэл шийтгэл хүлээхээр заасан үйлдлийг хийх, эсвэл тийм үйлдлээс татгалзахыг шаардахгүй бөгөөд тухайн үйлдлийг хийснээр тус Тал эсвэл түүний Хамаарал бүхий этгээдүүд Хориг арга хэмжээний дагуу сөрөг үр дагавартай арга хэмжээнд өртөх эрсдэлтэй нөхцөлд мөн адил хамаарна.

15.13 Нийлүүлэгч нь өөрийн ажилтан, туслан гүйцэтгэгч, төлөөлөгчид энэхүү Гэрээнд заасан Хориг арга хэмжээтэй холбоотой заалтуудыг дагаж мөрдөхийг хангах бүх боломжит арга хэмжээг авна. Үүнд (гэхдээ үүгээр хязгаарлагдахгүйгээр) холбогдох бодлого, журам боловсруулах, хадгалах, сургалт зохион байгуулах орно.

15.14 Хэрэв Санкцын улмаас Гэрээг гүйцэтгэхэд нөлөөлөх нөхцөл байдал үүсвэл Тал бүр хуулиар зөвшөөрөгдсөн ерөнхий лицензийг ашиглан Гэрээг хэрэгжүүлэх боломжийг судалж хэрэгжүүлнэ. Тодорхойлох үүднээс хэлбэл, энэхүү Гэрээ нь аливаа Талыг тусгай лиценз, зөвшөөрөл заавал хүсэхийг шаардахгүй.

15.15 Хэрэв Нийлүүлэгч нь энэхүү Гэрээний Зүйлүүд 15.1, 15.10 эсвэл 15.11-д тус тус заасан аливаа мэдэгдэл, баталгаат зөрчсөн, эсвэл Сэндвикийн үндэслэл бүхий үзэж байгаагаар ийм зөрчил гарах магадлалтай тохиолдолд Сэндвик нь өөрийн үзэмжээр Нийлүүлэгчтэй тогтоосон харилцаагаа нэн даруй цуцлах эсвэл түр зогсоох эрхтэй гэдгийг Талууд зөвшөөрнө. Үүнтэй холбоотойгоор Сандвик нь гэрээ цуцалсан эсвэл түр зогсоосны улмаас энэхүү Гэрээгээр хүлээсэн үүргээ цаашид биелүүлээгүйн төлөө Нийлүүлэгч болон аливаа гуравдагч этгээдийн өмнө хариуцлага хүлээхгүй бөгөөд Нийлүүлэгч нь ийнхүү үүргээ биелүүлээгүйтэй холбоотой эсвэл тухайн мэдэгдэл, баталгаат зөрчсөнөөс үүдэн гарсан аливаа нэхэмжлэл, хохирлыг бүрэн хариуцаж, Сэндвикийг хохиролгүй болгоно.

15.16 Хэрэв Сэндвик нь Зүйл 15.12-д заасны дагуу Гэрээний үйлчлэлийг түр зогсоохоор шийдвэрлэсэн тохиолдолд: (a) Нийлүүлэгч нь түр зогсоох тухай бичгээр мэдэгдэл хүлээн авмагц Бараа нийлүүлэх аливаа үйл ажиллагаагаа нэн даруй зогсооно; (b) Нийлүүлэгч нь Зүйлүүд 15.1, 15.7 болон 15.8-д тус тус заасны дагуу хүлээсэн үүргийн биелэлттэй холбоотой мэдээллийг, ийм мэдээлэл авах тухай энгийн хүсэлт гаргаснаас хойш 2 (хоёр) долоо хоногийн дотор Сэндвикд гаргаж өгөх үүрэгтэй; (c) Гэрээний үйлчлэлийг түр зогсоох аливаа хугацаа нь 120 хүртэлх хоног үргэлжилнэ. Хэрэв энэ хугацааны дараа Сэндвик нь Нийлүүлэгчийг энэхүү Гэрээний 15.1, 15.7 болон 15.8 дугаар Зүйлүүдийг дагаж мөрдөж байгаагаа баталгаажуулж чадахгүй бол Гэрээг нэн даруй цуцлахаар шийдвэрлэж болно; (d) Гэрээний үйлчлэлийг түр зогсоосон шийдвэрийг хүчингүй болгохын тулд Сэндвик нь түр зогсоох хугацаа

Copyright © 2026 Sandvik Group – All rights reserved

15.17 Supplier shall indemnify and keep Sandvik indemnified from and against all and any claims, losses, damages, costs and expenses (including reasonable attorneys' fees) suffered or incurred in any jurisdiction by Sandvik in relation to i) any failure by the Supplier to comply with Sanctions, including liabilities relating to any steps or actions which are required to be taken by the Supplier to remedy any such failures; and ii) any breach of Clause 15 of this Agreement by the Supplier.

16 FORCE MAJEURE

16.1 Neither Party shall be liable in respect of any breach or non-performance of the Agreement if and to the extent that such Party is prevented or delayed from performing its obligations under the Agreement due to extraordinary circumstances outside such Party's control and provided that such circumstances could not have been avoided by such Party and were not foreseeable at the time of execution of the Agreement. Force Majeure events shall not include financial difficulties, industrial action of a Party's own personnel, non-performance of a sub-supplier, shortage or lack of material or resources or shortage of transport. The Parties agree that a force majeure event will not arise in connection with any Sanctions.

16.2 A Party who wishes to rely on an impediment referred to in Clause 16.1 above for discharge of its obligations hereunder must, without delay, inform the other Party thereof. A corresponding duty to inform the other Party shall apply when the impediment, which the Party has relied on for release of its obligations, has come to an end.

16.3 If the fulfilment of the Agreement or a delivery thereunder is delayed or is likely to be delayed for at least three (3) months due to Force Majeure, each Party is entitled to terminate the Agreement with immediate effect upon providing the other Party with written notification.

17 TERMINATION

17.1 Without prejudice to any other right or remedy available under the Agreement, law or these Conditions, either Party shall have the right to terminate the Agreement and any or all Purchase Orders with immediate effect and without compensation to the other Party if; (a) to the extent permitted by the applicable law, the other Party should pass a resolution, or any court should make an order, that the other Party shall be wound up or if a trustee in bankruptcy, liquidator, receiver, or manager on behalf of a creditor should be appointed or if circumstances shall arise which would entitle the court or a creditor to make a winding-up order or if it otherwise is likely that the other Party is insolvent in the reasonable opinion of the other Party; or (b) a Party has committed a material breach of the Agreement (including Sandvik Supplier Code of Conduct, Sanctions, ABC-Laws and Anti-Slavery Laws), and if rectifiable, not rectified the same within thirty (30) days after receipt of a written notice specifying the breach. For the purpose hereof, a breach of any Sanctions, ABC-Laws, Anti-Slavery Laws or Sandvik Supplier Code of Conduct shall for the purpose of the Agreement not be considered to be rectifiable; or (c) in the event that a Force Majeure situation has not been cured within three (3) months.

17.2 Sandvik shall have the right to terminate the Agreement or a part of it with immediate effect and without compensation to Supplier if Supplier ceases to carry out its business or the ownership or control of Supplier or a material part of its business change.

18 AFTER MARKET, BRANDING AND STOCK

18.1 During the validity of the Agreement and for a period of ten (10) years after its termination or expiration, Supplier shall offer to sell and deliver spare parts relating to the Goods to Sandvik. Supplier shall offer such spare parts at commercially reasonable terms, prices and delivery terms. However, due to the fact that the lifetime of the Sandvik products often exceeds ten (10) years, all phase outs of the Goods are to be planned by Sandvik and Supplier in advance.

18.2 On a written request of Sandvik, Supplier shall free of charge brand the Goods, the packaging, the labels and/or the Documentation with the Sandvik trade names and/or trademarks identified by Sandvik in writing. Supplier must comply with any instructions and brand guidelines provided by Sandvik regarding the use of Sandvik trade names and/or trademarks. Also, on request of Sandvik Supplier shall use Sandvik part-numbers in lieu or in addition of its own part-numbers.

18.3 In case Sandvik reasonably identifies excess or surplus stock within 12 months after delivery, Supplier shall buy-back such Goods, on the condition that such Goods are reusable and resalable, and with the exclusion of Goods made specially for Sandvik. The buy-back price shall be the current purchase price and shipping shall be done at Sandvik's expense.

дуусгавар болсныг баталгаажуулсан мэдэгдлийг Нийлүүлэгчид бичгээр хүргүүлэх үүрэгтэй.

15.17 Нийлүүлэгч нь i) Хориг арга хэмжээг дагаж мөрдөөгүй аливаа зөрчил, үүний дотор уг зөрчлийг арилгахын тулд Нийлүүлэгчийн зүгээс авах шаардлагатай үйлдэл, арга хэмжээнээс үүдэлтэй үүрэг хариуцлага; болон ii) Нийлүүлэгч энэхүү Гэрээний 3үйл 15-д заасныг зөрчсөнтэй холбоотойгоор Сэндвикт учирсан болон/эсхүл гарсан аливаа шүүхийн харьяалалд үүссэн бүх нэхэмжлэл, хохирол, алдагдал, зардал болон төлбөр (үүнд өмгөөлөгчийн үндэслэл бүхий хөлс багтана)-ийг бүрэн хариуцаж, Сэндвикийг хохиролгүй болгоно.

16 ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

16.1 Хэрэв аль нэг Тал нь өөрийн хяналтаас гадуурх, онцгой нөхцөл байдлын улмаас Гэрээний дагуу үүргээ гүйцэтгэж чадахгүй болсон, эсхүл үүргээ биелүүлэхэд саад учирсан бөгөөд уг нөхцөл байдал нь тухайн Талын зүгээс зайлсхийх боломжгүй, мөн Гэрээг байгуулах үед урьдчилан таамаглах боломжгүй байсан бол тухайн зөрчил, эсхүл үүргээ гүйцэтгээгүй нөхцөлд аль ч Тал хариуцлага хүлээхгүй. Давагдашгүй хүчин зүйлийн нөхцөл байдалд санхүүгийн хүндрэл, Талын өөрийн ажилтнуудын ажил хаялт, туслан нийлүүлэгчийн гэрээний үүргийг биелүүлээгүй, материал эсвэл нөөцийн дутагдал, хомсдол, эсвэл тээвэрийн хэрэгслийн хомсдол зэрэг нь үүнд хамаарахгүй. Түүнчлэн аливаа Хориг арга хэмжээтэй холбоотой нөхцөл байдлыг давагдашгүй хүчин зүйлийн тохиолдолд тооцохгүй байхаар Талууд тохиролцов.

16.2 Энэхүү Гэрээгээр хүлээсэн үүргээсээ чөлөөлөгдөхийн тулд дээрх Зүйл 16.1-д заасан саад бэрхшээлийг үндэслэл болгохыг хүсэж буй Тал нь нөгөө Талдаа энэ тухай нэн даруй мэдэгдэнэ. Аль нэг Тал нь өөрийн үүргээс чөлөөлөгдөх үндэслэл болгосон тухайн саад бэрхшээл дуусгавар болох үед нөгөө Талдаа мэдэгдэх үүрэг мөн адил хүлээнэ.

16.3 Хэрэв Гэрээний биелэлт эсвэл түүний дагуу хийгдэх нийлүүлэлт нь Давагдашгүй хүчин зүйлийн улмаас багадаа 3 (гурав) сарын хугацаагаар хойшилсон эсвэл хойшлох магадлалтай болсон тохиолдолд Тал тус бүр нөгөө Талдаа бичгээр мэдэгдэл хүргүүлснээр Гэрээг нэн даруй цуцлах эрхтэй.

17 ЦУЦЛАЛТ

17.1 Гэрээ, хууль тогтоомж эсвэл энэхүү Гэрээний дагуу эдлэх боломжтой бусад аливаа эрх, эрх зүйн хамгаалалтыг хөндөхгүйгээр, дараах тохиолдолд Талуудын аль нэг нь Гэрээг болон аливаа эсвэл бүх Захиалгын хуудсыг нөгөө Талдаа ямар нэгэн нөхөн олговор олгохгүйгээр нэн даруй цуцлах эрхтэй байна. Үүнд: (a) Холбогдох хуулиар зөвшөөрөгдсөн хэмжээнд, нөгөө Талыг татан буулгах тухай тогтоол гарсан, эсвэл үүнтэй холбоотой шүүхийн шийдвэр гарсан бол, эсвэл зээлдэгчийн нэрийн өмнөөс дампуурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, татан буулгагч, хүлээн авагч эсвэл удирдагч томилогдсон бол, эсвэл шүүх эсвэл зээлдэгчээс татан буулгах шийдвэр гаргах үндэслэл бүхий нөхцөл байдал үүссэн бол, эсвэл нөгөө Талын үндэслэл бүхий үзэж байгаагаар тухайн аль нэг Тал төлбөрийн чадваргүй болсон байх магадлалтай тохиолдолд; эсхүл (b) Аль нэг Тал нь Гэрээг (үүнд Сэндвикийн Нийлүүлэгчийн ёс зүйн дүрэм, Хориг арга хэмжээ, Авлигын эсрэг хууль тогтоомж болон Албадан хөдөлмөр, боолчлолын эсрэг хууль багтана) ноцтой зөрчсөн бөгөөд уг зөрчлийг засах боломжтой байхад зөрчлийн талаар бичгээр гаргасан мэдэгдлийг хүлээн авснаас хойш 30 (гуч) хоногийн дотор уг зөрчлийг шийдвэрлээгүй бол. Үүнтэй холбогдуулан Хориг арга хэмжээ, Авлигын эсрэг хууль тогтоомж, Албадан хөдөлмөр, боолчлолын эсрэг хууль эсхүл Сэндвикийн Нийлүүлэгчийн ёс зүйн дүрмийг зөрчсөн аливаа зөрчлийг энэхүү Гэрээний зорилгоор шийдвэрлэх боломжгүй зөрчилд тооцно; эсхүл (c) Давагдашгүй хүчин зүйлийн нөхцөл байдлыг 3 (гурав) сарын дотор арилаагүй, шийдвэрлэгдээгүй тохиолдолд.

17.2 Хэрэв Нийлүүлэгч үйл ажиллагаагаа зогсоосон, эсхүл Нийлүүлэгчийн өмчлөл, удирдлага, хяналт, эсхүл түүний бизнесийн чухал хэсэгт өөрчлөлт орсон бол Сэндвик нь Гэрээг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн нэн даруй, Нийлүүлэгчид нөхөн төлбөр олголгүйгээр цуцлах эрхтэй.

18 ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛ, БРЭНДИНГ БА НӨӨЦ

18.1 Гэрээний хүчин төгөлдөр хугацаанд болон Гэрээ дуусгавар болсноос хойш 10 (арав) жилийн хугацаанд Нийлүүлэгч нь Бараанд хамаарах сэлбэг хэрэгслийг Сэндвикд худалдах болон ханган нийлүүлэхийг санал болгох үүрэгтэй. Нийлүүлэгч нь тухайн сэлбэг хэрэгслийг арилжааны хувьд үндэслэл бүхий нөхцөл, үнэ, ханган нийлүүлэлтийн нөхцөлөөр санал болгоно. Гэсэн хэдий ч Сэндвикийн бүтээгдэхүүн ашиглалтын хугацаа нь ихэвчлэн 10 (арав) жилээс урт байдаг тул Барааг зах зээлээс гаргах асуудлыг Сэндвик болон Нийлүүлэгч урьдчилан хамтран төлөвлөнө.

18.2 Сэндвикийн бичгээр гаргасан хүсэлтийн дагуу Нийлүүлэгч нь Бараа, сав баглаа боодол, шошго болон/эсвэл Баримт бичигт Сэндвикийн бичгээр зааж өгсөн худалдааны нэр болон/эсвэл барааны тэмдгийг үнэ төлбөргүйгээр байршуулах үүрэгтэй. Нийлүүлэгч нь Сэндвикийн худалдааны нэр болон/эсвэл барааны тэмдгийг ашиглах талаар Сэндвикаас өгсөн аливаа зааварчилгаа, брэндийн удирдамжийг дагаж мөрдөнө. Түүнчлэн, Сэндвикийн хүсэлтээр Нийлүүлэгч нь өөрийн эд ангийн дугаарын оронд эсвэл түүний дээр нэмэлтээр Сэндвикийн эд ангийн дугаарыг ашиглана.

18.3 Барааг нийлүүлснээс хойш 12 сарын дотор Сэндвик илүү, хэрэгцээт бус нөөц байгааг үндэслэлтэйгээр тогтоосон тохиолдолд Нийлүүлэгч нь тухайн Барааг буцаан худалдаж авах үүрэгтэй. Энэ нь уг Барааг дахин ашиглах, борлуулах боломжтой байх нөхцөлд үйлчлэх бөгөөд зөвхөн Сэндвикд зориулан тусгайлан үйлдвэрлэсэн Бараанд

Copyright © 2026 Sandvik Group – All rights reserved

19 APPLICABLE LAW AND DISPUTES

19.1 Any dispute arising out of or in connection with the Agreement (including any question regarding its existence, validity or termination) shall be governed by the laws of English Law.

19.2 The submission to arbitration shall not limit the right of Sandvik to take proceedings against the Supplier in any court which may otherwise exercise jurisdiction over the Supplier or any of its assets.]

19.3 Any dispute, controversy or claim arising out of or in connection with the Agreement shall be finally settled by arbitration administered by the Singapore International Arbitration Centre (the "**SIAC**") in accordance with the Arbitration Rules of the Singapore International Arbitration Centre ("**SIAC Rules**") for the time being in force, which rules are deemed to be incorporated by reference in this Clause. The place for such proceedings shall be Singapore. The arbitration proceedings, information disclosed during the arbitration proceedings and the result of such proceedings is subject to confidentiality.

20 Security Interest

20.1 Unless otherwise defined, capitalised terms and expressions used in this Clause 20 shall have the meanings given to them under applicable law.

20.2 Sandvik acknowledges that the Supplier may have a Security Interest in the Goods, securing Sandvik's obligations under the Agreement. The Supplier's Security Interest in the Goods shall cease without the need for any further action by the Supplier upon title to the Goods passing to Sandvik in accordance with this Agreement.

20.3 Sandvik agrees to provide any information reasonably requested by the Supplier in order to enable the Supplier to register any Security Interest on relevant Mongolian registration authority the arising under this Agreement in accordance with applicable law and to notify the Supplier in writing of any change in Sandvik's details.

20.4 The Supplier agrees to promptly take all reasonable steps necessary to discharge or release any Security Interest registered by it in connection with this Agreement upon title to the Goods passing to Sandvik in accordance with this Agreement.

21 PROHIBITED IMPORTS

21.1 The Supplier warrants that Goods covered by a Purchase Order are not a prohibited import as defined under applicable Mongolian law and that the Goods may be legally imported into Mongolia. The Supplier will indemnify and save harmless Sandvik from all loss or damage arising from breach of this warranty.

21.2 Supplier shall always provide Sandvik without undue delay and in appropriate language: A valid Certificate of Origin for supplied Goods (including included US components); a valid HS Code; a valid Long Term Declaration or a certificate of preferential origin; a declaration of conformity; a valid item test certificate; the current customs certification program participation status (CTPAT, AEO, etc.); an up to date MSDS sheet; an ECCN relating to the Good; and advanced manifest details.

22 MISCELLANEOUS

22.1 If part of the Agreement is or becomes invalid or non-binding, the Parties shall remain bound to the remaining part. The Parties shall replace the invalid or non-binding part by provisions which are valid and binding and the effect of which, given the contents and purpose of the Agreement, is, to the greatest extent possible, similar to that of the invalid or non-binding part.

22.2 The rights and obligations of the Parties, which by express provision or by nature extend beyond the termination of the Agreement, shall survive the termination of the Agreement (including but not limited to, warranties, confidentiality, applicable law and settlement of disputes).

22.3 Neither Party shall have the right to assign the Agreement or a separate Purchase Order or any of its rights or obligations hereunder to any third party without the prior written consent of the other Party, which shall not be unreasonably withheld. Notwithstanding the above-stated, Sandvik shall always be entitled to assign the Agreement or a separate Purchase Order or its rights and obligations thereunder to its Affiliates or to a third party to which the business subject to the Agreement or a separate Purchase Order is sold or transferred, upon written notice to Supplier.

22.4 A waiver by a Party concerning the other Party's breach of the Agreement shall not be construed as a waiver of subsequent breaches against the same or another term of the Agreement.

22.5 All notifications or consents relating to the Agreement or a separate Purchase Order shall be made in writing in the English language to a contact person nominated by each Party by mail, email or another mutually agreed manner in accordance with the contact details given by such Party.

хамаарахгүй. Буцаан худалдаж авах үнэ нь тухайн үеийн худалдан авалтын үнэ байх бөгөөд тээвэрлэлтийг Сэндвикийн зардлаар гүйцэтгэнэ.

19 ХЭРЭГЛЭХ ХУУЛЬ БА МАРГААН

19.1 Гэрээнээс үүдэн гарсан, эсхүл Гэрээтэй холбоотой аливаа маргаан (үүнд Гэрээ байгуулагдсан эсэх, түүний хүчин төгөлдөр байдал, эсхүл дуусгавар болохтой холбоотой асуудлуудыг оролцуулан) нь Англи Улсын хууль тогтоомжийн дагуу зохицуулагдана.

19.2 Арбитраар маргааныг шийдвэрлүүлэхээр тохиролцсон нь Сэндвикийн Нийлүүлэгч эсхүл түүний аливаа хөрөнгөд харьяалал хэрэгжүүлэх боломжтой аливаа шүүхэд нэхэмжлэл гаргах эрхийг хязгаарлахгүй.]

19.3 Гэрээнээс үүдэлтэй эсхүл түүнтэй холбоотойгоор үүссэн аливаа маргаан, зөрчил, гомдлыг Сингапурын Олон Улсын Арбитрын Төв ("**СОУАТ**")-д тухай үед хүчин төгөлдөр мөрдөгдөж буй энэхүү Зүйлд иш татан оруулсан гэж үзэх Сингапурын Олон Улсын Арбитрын Төвийн Дүрэм ("**СОУАТ-ийн Дүрэм**")-ийн дагуу эцэслэн шийдвэрлүүлнэ. Арбитрын ажиллагаа явуулах газар нь Сингапур байна. Арбитрын ажиллагаа, түүний явцад ил болсон мэдээлэл болон гарсан шийдвэр нь нууцлалд хамаарна.

20 БАРЬЦААНЫ ЭРХ

20.1 Өөрөөр тодорхойлоогүй бол энэхүү Зүйл 20-д хэрэглэсэн том үсгээр эхэлсэн нэр томьёо болон хэллэгүүд нь холбогдох хууль тогтоомжид заасантай ижил утгатай байна.

20.2 Гэрээний дагуу хүлээсэн Сэндвикийн үүргийн гүйцэтгэлийг хангуулах зорилгоор Нийлүүлэгч нь Бараанд Барьцааны эрх эдлэх боломжтойг Сэндвик хүлээн зөвшөөрнө. Энэхүү Гэрээний дагуу Бараг өмчлөх эрх Сэндвикт шилжсэн үеэс эхлэн Нийлүүлэгчийн зүгээс ямар нэгэн нэмэлт үйлдэл хийх шаардлагагүйгээр уг Бараанд холбогдох Нийлүүлэгчийн Барьцааны эрх дуусгавар болно.

20.3 Сэндвик нь энэхүү Гэрээний дагуу үүсэж буй Барьцааны эрхтэй холбогдуулан холбогдох хууль тогтоомжийн дагуу Монгол Улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэх боломжийг олгох үүднээс Нийлүүлэгчийн үндэслэл бүхий шаардсан аливаа мэдээллийг Нийлүүлэгчид гаргаж өгөх бөгөөд Сэндвик нь өөрийн мэдээлэлд орсон аливаа өөрчлөлтийн талаар Нийлүүлэгчид бичгээр мэдэгдэнэ.

20.4 Нийлүүлэгч нь энэхүү Гэрээний дагуу Бараг өмчлөх эрх Сэндвикд шилжсэн үеэс эхлэн уг Гэрээтэй холбогдуулан бүртгүүлсэн аливаа Барьцааны эрхтэй холбоотой бүх шаардлагатай арга хэмжээг авч, уг Барьцааны эрхийг хүчингүй болгоно.

21 ХОРИГЛОСОН ИМПОРТ

21.1 Нийлүүлэгчийн Захиалгын хуудаст хамаарах Бараа Монгол Улсын холбогдох хууль тогтоомжоор тодорхойлсноор импортлохыг хориглосон бараа биш бөгөөд уг Бараг Монгол Улсад хууль ёсоор импортолж болно гэсэн баталгаг Нийлүүлэгч гаргана. Энэхүү баталгаг зөрчсөнөөс үүдэн гарсан аливаа хохирол, алдагдлаас Сэндвикийг чөлөөлж, Нийлүүлэгч хариуцана.

21.2 Нийлүүлэгч нь дараах баримт бичиг, мэдээллийг үндэслэлгүйгээр хугацаа хэтрүүлэлгүй, зохих хэл дээр Сэндвикд тухай бүр гаргаж өгөх үүрэгтэй: Нийлүүлсэн Барааны хүчин төгөлдөр гарал үүслийн гэрчилгээ (АНУ-ын Бараанд хамаарах бүрэлдэхүүн хэсгүүдийг оролцуулан); хүчин төгөлдөр HS код; хүчин төгөлдөр Урт хугацааны мэдүүлэг эсвэл хөнгөлөлттэй барааны гарал үүслийн гэрчилгээ; тохирлын гэрчилгээ; хүчин төгөлдөр барааны туршилтын гэрчилгээ; гаалийн гэрчилгээжүүлэлтийн хөтөлбөрт хамрагдсан эсэх (CTPAT, AEO гэх мэт); хамгийн сүүлийн үеийн MSDS (материалын аюулгүй ажиллагааны мэдээллийн хуудас); Бараанд холбогдох ECCN (Экспортын хяналтын ангиллын дугаар); болон ачааны урьдчилсан дэлгэрэнгүй мэдээлэл.

22 БУСАД ЗҮЙЛ

22.1 Хэрэв Гэрээний аль нэг хэсэг хүчин төгөлдөр бус буюу заавал биелэгдэх шинжгүй болсон тохиолдолд Талууд Гэрээний үлдсэн хэсгийг үргэлжлүүлэн дагаж мөрдөнө. Талууд уг хүчин төгөлдөр бус заалтыг Гэрээний агуулга, зорилготой хамгийн ойролцоо үр нөлөөтэй, хууль ёсоор хүчинтэй заалтаар орлуулна.

22.2 Талуудын эрх үүрэг нь илэрхий заалтаар эсхүл мөн чанарын хувьд Гэрээ дуусгавар болсны дараа ч хүчин төгөлдөр байх тохиолдолд тухайн эрх, үүрэг нь хүчин төгөлдөр хэвээр байна (үүнд баталгаа, нууцлал, хэрэглэх хууль, маргаан шийдвэрлэлт зэргийг оролцуулаад гэхдээ хязгаарлагдахгүйгээр).

22.3 Аль ч Тал нь нөгөө Талын урьдчилан бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр (энэ зөвшөөрлийг үндэслэлгүйгээр татгалзах ёсгүй) Гэрээ эсхүл Захиалгын хуудсыг, эсхүл энэхүү Гэрээгээр хүлээсэн аливаа эрх, үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэх эрхгүй бөгөөд тухайн зөвшөөрлийг олгохоос үндэслэлгүйгээр татгалзах эрхгүй. Дээр дурдсаныг үл харгалзан, Сэндвик нь Нийлүүлэгчид бичгээр мэдэгдсэний үндсэн дээр Гэрээ эсвэл тусдаа Захиалгын хуудас эсхүл тэдгээрийн дагуу хүлээсэн эрх, үүргээ өөрийн Нэгдмэл сонирхолтой этгээдүүд болон тухайн Гэрээ буюу Захиалгын хуудсанд хамаарах бизнесийг худалдаж авсан гуравдагч этгээдэд шилжүүлэх эрхтэй.

22.4 Аль нэг Тал нөгөө Талынхаа Гэрээ зөрчсөн үйлдэлд хариуцлага тооцох эрхээсээ татгалзсан явдал нь цаашид тухайн заалтыг эсвэл Гэрээний өөр заалтыг дахин зөрчих тохиолдлуудад мөн хариуцлага тооцох эрхээсээ татгалзсанд тооцогдохгүй.

22.5 Гэрээ эсхүл Захиалгын хуудастай холбоотой бүх мэдэгдэл, зөвшөөрлийг талуудын томилсон холбоо барих этгээдэд англи хэлээр, шуудан, и-мэйл, эсхүл Талууд харилцан тохиролцсон бусад аргаар, тухайн Талаас өгсөн холбоо барих мэдээллийн дагуу бичгээр

Copyright © 2026 Sandvik Group – All rights reserved

23 Prevailing Language

23.1 In the event of any discrepancy between the English and the Mongolian versions of these Conditions, the English version shall prevail.

хүргүүлнэ.

23 Баримтлах хэл

23.1 Эдгээр Нөхцөлүүдийн англи болон монгол хэл дээрх хувилбаруудын хооронд зөрүү гарсан тохиолдолд англи хэл дээрх хувилбарыг дагаж мөрдөнө.

Copyright © 2026 Sandvik Group – All rights reserved